

Цагаачлалын талаарх асуудлыг Холбооны Мажистрэйт Шүүх хянах нь

Энэ зөвлөмж хэнд зориулагдсан бэ?

Энэхүү зөвлөмж нь Австралийн Холбооны Мажистрэйт Шүүхээр (Federal Magistrates Court of Australia) өөрийнхөө визтэй холбоотой шийдвэрийг дахин хянаж өгөхийг хүссэн хүмүүст зориулагдсан.

Ямар шийдвэрийг Шүүх хянаж үзэх эрхтэй вэ?

1958 оны Цагаачлалын Хуулийн (Migration Act 1958) дагуу гаргасан зарим шийдвэрийг Холбооны Мажистрэйт Шүүх /цаашид Шүүх гэнэ/ нь хянаж үзэх эрхтэй байдаг. Цагаачлалын Хуулийн дагуу шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад Иргэншил болон Цагаачлалын Асуудал эрхэлсэн сайд, Дүрвэгсдийн Хэргийг Хянах Шүүх (Refugee Review Tribunal) болон Цагаачлалын Хэргийг Хянах Шүүхийн (Migration Review Tribunal) гишүүд ордог.

Шүүх дээрх байгууллагууд шийдвэр гаргах явцдаа зөвхөн "хууль эрх зүйн алдаа" ('jurisdictional error') гаргасан байгаа эсэхийг л хянаж үзэх эрхтэй байдаг. Энэ нь шийдвэр гаргах явц хуульд бүрэн нийцсэн байсан уу гэдгийг хянаж тодорхойлдог гэсэн үг юм.

Шүүх юу шийдэж чадах вэ?

Хэрэв Шүүх таны өргөдлийг хянаж үзээд таны талд шийдсэн бол таны хэргийг шийдвэр гаргасан эрх бүхий хүмүүс рүү буцаана. Мөн Шүүх нь Иргэншил болон Цагаачлалын Асуудал эрхэлсэн Сайд өөрт олгогдсон бүрэн эрхийн дагуу таны асуудал дээр шийдвэр гаргахыг зогсоох хүртэл арга хэмжээ авч чадна.

Шүүх юуг шийдэж чадахгүй вэ?

Шүүх нь таны гаргасан өргөдлийг үндэслэн танд виз олгох ёстой эсэхийг шийдэх эрхгүй.

Шүүх бие даасан, гадны нөлөөнд автахгүй байгууллага мөн үү?

Тийм, Шүүх нь Цагаачлалын хуулийн дагуу шийдвэр гаргах эрх бүхий хүмүүсээс хамааралгүй бие даасан байгууллага юм.

Хэн Шүүхэд өргөдөл гаргах эрхтэй вэ?

Хэрэв та өөрийн цагаачлалын асуудлаар гаргасан шийдвэртэй санал нийлэхгүй байгаа бөгөөд энэхүү шийдвэр гарах явцад хууль зүйн алдаа гарсан гэж үзэж байгаа бол та Шүүхэд өргөдөл гаргаж болно. Шүүхэд өргөдлөө оруулахын өмнө энэ талаараа хууль зүйн зөвлөгөө авахыг танд зөвлөж байна.

Шүүхийн хурал хаалттай болдог уу?

Ерөнхийдөө шүүхийн хурлууд олон нийтэд нээлттэй болдог. Гэхдээ таны хэрэг нь дүрвэгсдийн цагаачлалын талаар бол Шүүх таны нэр овог зэрэг хувь хүнтэй холбоотой мэдээллийг гадагш олон нийтэд нийтлэн зарлахгүй байх үүрэгтэй.

Өргөдөл гаргахад цаг хугацааны ямар нэг хязгаарлалт бий юу?

Эрх бүхий байгууллага таны хэрэг дээр шийдвэрээ гаргасан өдрөөс хойш 35 хоногийн дотор та Шүүхэд өргөдлөө гаргах ёстой. Зарим тохиолдолд Шүүх танд энэ хугацааг сунгаж өгч болно. Та хугацаагаа сунгуулахыг хүсч байгаа бол өргөдөлдөө энэ тухайгаа тайлбарлаж, хугацаа сунгахыг хүсэх ёстой.

Өргөдөл гаргахад ямар маягт надад хэрэг болох вэ?

Шүүхэд хэргээ дахин хянуулахаар өргөдөл оруулахдаа дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- өргөдөл
- үнэнийг тангарагласан мэдүүлэг (affidavit).

Та эдгээр баримтуудын загварыг www.fmc.gov.au гэсэн веб хаягаар орж авч болох ба эсвэл ойроцоох Шүүхийн Бүртгэлийн хэлтэст (court registry) очиж авч болох юм.

Та өргөдөлдөө таны хэрэг дээр шийдвэр гаргасан байгууллага хууль эрх зүйн ямар алдаа гаргасан талаар үндэслэлээ тодорхой гаргаж бичсэн байх ёстой. Үнэнийг тангарагласан мэдүүлэгтээ алдаа гарсан талаарх бүхий л холбогдох баримтыг хавсаргаж, нөхцөл байдлын талаар тайлбарлаж бичсэн байх ёстой. Түүнээс гадна таны хэрэг дээр гаргасан шийдвэрийн хувь болон шийдвэртэй холбогдсон баримтуудыг үнэнийг тангарагласан мэдүүлэгтээ хавсаргаарай.

Бичиг баримтуудаа хэнд өгөх вэ?

Бичиг баримт чинь бэлэн болсон бол та өөрийн өргөдөл болон холбогдох баримтуудаа Шүүхэд өгөх хэрэгтэй. Үүний дараа та Шүүхэд оруулсан өргөдөл болон бусад баримтуудын нэг хувийг битүүмжилж таны цагаачлалын хэрэг дээр шийдвэр гаргасан газарт (Иргэншил болон Цагаачлалын Асуудал эрхэлсэн Сайд юм уу Дүрвэгсдийн Хэргийг Хянах Шүүх, эсвэл Цагаачлалын Хэргийг Хянах Шүүх гэх мэт) аваачиж өгөх шаардлагатай. Энэ явцыг баримт өргөн мэдүүлэх (service of documents) гэнэ.

Та баримт өргөн мэдүүлэхдээ Иргэншил болон Цагаачлалын Асуудал эрхэлсэн Яамны (Department of Immigration and Citizenship) тухайн орон нутаг дахь салбараар дамжуулж хийж болно. Иргэншил болон Цагаачлалын Асуудал эрхэлсэн Яам нь муж улс бүрт өөрийн байртай. Тэдгээрийн хаягийг та www.immi.gov.au гэсэн веб хаягаар орох буюу **131 881** гэсэн утсаар лавлаж болно.

Шүүх хурлын үеэр юу болох вэ?

Шүүхээс таны өргөдлийг хэлэлцэх хурлын өдрийг товлон. Хурлаас доорх шийдвэрүүдийн аль нэгийг гаргах боломжтой.

- хэргийг хэлэлцэх хурлыг шууд эхлүүлэх
- хэргийг хэлэлцэх 2 дах хурал эсвэл эцсийн хурлыг дараа явуулахаар болж он сар товлон
- түр зуурын шийдвэрийг гаргаж мөрдүүлэх
- нэмэлт болон тодруулга хийсэн бичиг баримт нийлүүлэх хугацаа товлон.

Хэрэв хэргийг хэлэлцэх хурлыг шууд эхлүүлэх юм уу эсвэл хоёр дахь хуралдааныг эцсийн хуралдаан товлонгүйгээр хийх шийдвэр Шүүхээс гарсан тохиолдолд та өөрийн асуудлаа маргаантай (arguable case) гэдгийг нотлох шаардлага гарч болзошгүй. Хэрэв та үүнийгээ Шүүхэд харуулж чадахгүй бол Шүүх таны хэргийг хойшуулалгүйгээр шийдвэр гаргах магадлалтай.

Шүүх аль ч хурлын үед танд өөрийнхөө хэрэгтэй холбоотой асуудлаар ярих боломжийг олгодог. Хэрэв та хуралд өөрийн хуульчийн хамт оролцож байгаа бол тэр таны өмнөөс ярих болно. Иргэншил болон Цагаачлалын Асуудал эрхэлсэн Сайдыг төлөөлж тэдний хуульч ихэнхдээ хуралдаанд оролцдог ба та болон таны өмгөөлөгч тэдний асуултанд хариулах боломжтой болно. Та Шүүхээс тусгай зөвшөөрөл аваагүй л бол хуралд заавал биеэр ирж оролцох ёстой.

Шүүх ихэнх тохиолдолд эцсийн хурлын төгсгөлд шийдвэрээ гаргадаг. Хэрэв тэгээгүй бол Шүүхийн шийдвэр гарах өдрийг танд мэдэгдэх болно.

Орчуулагчдын талаар

Та орчуулгын үйлчилгээний **131 450** гэсэн дугаараар холбогдон Шүүхтэй холбоо барьж болно. Та хурал дээр орчуулагчтай байхыг хүсвэл Шүүхэд оруулж буй өргөдөл дээрээ үүнийгээ бичих хэрэгтэй.

Би ямар нэгэн төлбөр төлөх ёстой юу?

Та өргөдлөө Шүүхэд оруулах үед тодорхой төлбөр төлөх ба мөн эцсийн хурлын төлбөрийг төлөх хэрэгтэй болно. Зарим үед төлбөр төлөх шаардлагагүй байдаг тохиолдол ч байдаг. Та энэ талаар илүү мэдээлэл авмаар байгаа бол Шүүхийн бүртгэлийн ажилтнуудтай уулзаж асуугаарай.

Хэрэв таны өргөдөл амжилтгүй болсон тохиолдолд та Иргэншил болон Цагаачлалын Асуудал эрхэлсэн Сайдын талын шүүхтэй холбоотой гарсан зардлыг ихэнхдээ төлөх хэрэгтэй болдог. Хэрэв та хэргээ хурал болохоос өмнө Шүүхээс татаж авбал та тэдний гаргасан зардын зөвхөн тодорхой хувийг л төлөх хэрэгтэй болдог.

Би хэргээ татаж авч болох уу?

Болно. Гэхдээ таны эцсийн хурал болоход 14-өөс бага хоног үлдсэн бол та хэргээ татаж авахын тулд Шүүхээс тусгай зөвшөөрөл авах хэрэгтэй.

Надад хуулийн зөвөлгөө авах хэрэг байна уу?

Та өргөдлөө оруулах талаар аль болох хурдан хуулийн зөвөлгөө авах нь зохимжтой. Та олон нийтийн хуулийн зөвөлгөө өгөх төвүүдээр үйлчлүүлж болох ба зарим хандив, тусламжийн газруудаас хууль зүйн үнэгүй зөвөлгөө авах боломж олдож ч магад. Аль эсвэл та хуульчтай гэрээ хийж хөлс төлөн үйлчлүүлэх хэрэгтэй болно.